

## Нэр томъёоны орчуулга<sup>111</sup>

Д.Дашдаваа, Э.Равдан

Эрдэм шинжилгээний болон шинжлэх ухаан-техникийн сэдвийг орчуулах үед нэр томъёоны асуудал гарч ирдэг. Нэр томъёо хам сэдвээсээ болж янз бүрийн ухагдахууны нэр болж шинжлэх ухаан, техникийн салбарт өргөн хэрэглэгддэг.

Нэр томъёо бас бусад үг адил хааяа салаа утгатай байдгийг дээр өгүүлсэн билээ. Тийм нэр томъёо тухайн эх бичигт ямар утгаараа орсныг ухаарч орчуулахдаа цаад тэмдэглэж буй ухагдахууныг сайтар мэдэх, мөн чанарыг ухаарах нь чухал. Тэгж л гэмээж нь орчуулга зөв болно.

Шинжлэх ухаан болон шинжлэх ухаан-техникийн холбогдолтой сэдвүүдийг орчуулахдаа голдуу цаад орчуулж байгаа хэлэнд бэлэн байгаа нэр томъёог давын өмнө ашигладаг.

Шинжлэх ухааны зарим нэр томъёонд орчуулж буй хэлэнд нь дүйх нэр томъёо байхгүй, эсвэл, даруй зохион оноож боломгүй бол орчуулагч л уг асуудлыг шийдэх болдог бөгөөд түүний хэлбичгийн боловсрол, үгийн язгуурын холбоог аль хэр мэдэх, хам сэдвээр нь нэр томъёоны бололцоот утгыг олж таних чадвар чухал үүрэгтэй.

Ямар нэг ухагдахууныг тэмдэглэсэн үг өөр өөр хэлэнд өнгө аясаараа тохирохгүй нэг хэлнээ нэр томъёо болж нөгөө хэлнээ янз бүрийн утгаар тэр ч байтугай яруу найрагт ч ордог байж болдог. Энэ талаах В.Шекспирийн сонетуудыг орос хэлэнд орчуулсан зөвлөлтийн нэрт яруу найрагч С.Маршакийн «центр» гэдэг үгийн талаархи дүгнэлт сонирхолтой юм.

Орчуулагч үгийн өнгө, аясыг мэдэрч байх ёстой. Шекспирийн 146-р сонет англи эх дээрээ «Моя душа-центр этой греховой земли» (Сэтгэл минь-энэ нүгэлт дэлхийн төв юм) гэж эхэлдэг. Англид «центр» гэдэг үг ромын байлдан дагуулалтын үе, Цезарийн үеэс л шахуу ярианд хэрэглэгдэх болсон. Манайд (орос хэлэн,-д орч) энэ үг ярианд сайн ороогүй, хүйтэвтэр, нэр томъёоны аястай. Шекспирийн сонатын энэ мөрийг орчуулахдаа би «центр» гэдэг үгийг орхиж өөр үг хайхад хүрсэн. Эцэст нь дээрх мөрийг «Моя душа-ядро земли греховой» (Үгч. Сэтгэл минь-нүгэлт хорвоогийн цөм билээ) гэж орчуулсан гэжээ /Ю.А.Бельчиков. Лексическая стилистика, М., 1977/.

<sup>111</sup> Д.Дашдаваа, Э.Равдан “Нэр томъёоны тухай”, УБ, 1980 /53-62 тал/

Нэр томъёог орчуулахдаа цаад гадаад хэлний нэр томъёоны утга санаанд тохирох үгийг эх хэлнээсээ оноож гаргах уу, гадаад үг зээлдэх үү гэдгийг зөв шийдэх ёстой.

Гадаад нэр томъёог орчуулганд бид нэлээд ашигладаг. Гэхдээ а) хэлний үгсийн санд баттай орж эх хэлний үгнээс өөрцгүй ойлгомжтой болсон үгс, трактор, комбайн, автобааз, автобус, автомат, агрегат, агроном, адмирал, академи(я), акт, альбом, анкет, ансамбль, ассистент, аспирант, атом, атташе гэх мэт.

Нөгөөтэйгүүр зарим гадаад нэр томъёо монгол хэлэнд ойролцоо утгатай нэр томъёотой авч, цаад ухагдахууныхаа утгыг нарийвчлан гаргах нь дээр буюу эсвэл монголоор олон үгээр буудаг зэргээс гадаад үгээр нь буулгадаг: аэродром (нисэх онгоцны буух нисэх газар) вокзал (төмөр замын буудал) гэдэг тээврийн нэр томъёог бид голдуу аэродром (онгоцны буудал) вокзал гэж хэлдэг. Монгол нэр нь бичигт хэт нүсэрдэх талтай олон үгээр буужээ. Харин эх хэлэнд бэлэн үг, нэр томъёо байгаад гадаад нэр томъёо нь төдийлөн нийтэд ойлгомжгүй бол гадаад үг хэрэглэх шаардлагагүй нь мэдээж. Эсвэл нарийн мэргэжлийн цөөн хүмүүст л ойлгомжтой, нийтэд ойлгомжгүй бол мөн нэгэн адил анхаарвал зохино.

Орчуулганд гадаад нэр томъёо хэрэглэх үү, монголоор нь авах уу гэдэг нь уг сэдвийн найруулгатай холбоотой. Цөөн мэргэжилтэнд зориулсан эрдэм-шинжилгээний зохиолд гадаад нэр, нийтэд зориулж байгаа үедээ (шинжлэх ухааны хялбаршуулсан ном зохиол, ярианд) монгол нэр голдуу хэрэглэдэг.

Нэр томъёо болгоныг орчуулах гэж дайраад монгол хэлээ олон улсын чанартай нэр томъёогоор баяжуулахгүй, гаднаас үг оруулахгүй гэж эх хэлээ тойруулж хана хэрэм босгох шаардлагагүй юм.

«Аливаа үндэстэн бусдаас суралцаж болох бөгөөд тэгэх ч ёстой» гэж К.Маркс «Капитал» зохиолдоо сургаж байсан. Шинжлэх ухаан техникийн ололтоос харилцан суралцаж, олон улсын чанартай нэр томъёо нийтийн хүртээл болох зүй ёсны хэрэг. Гэтэл гадаадын зарим үгийг (нэр томъёог) дүйх монгол үг, хэллэг байхгүйбол заавал ч үгүй монголчлох гэж хэт олон үгээр агуулгыг нь тайлбарлан орчуулах явдал байна. «Компьютер», «трамвай» гэсэн үгийг «тооцоолон бодох электрон машин», «гудамжнаа явах цахилгаан галт тэрэг» гэж 4-5 үгээр орчуулсан байдлыг эрдэмтэн С.Галсан буруушааж «... Компьютер» гэдгийг дэлхий дахинаа мэддэг үг болохоор 30 жил, 50 жилийн дараа манай хойд үе энэ ганц үгийг яах гэж ийм олон үгээр нуршуулан «орчуулбаа» гэж харамсах юм биш байгаа?<sup>112</sup> » гэж бичсэн нь бодууштай л зүйл.

Нэр томъёо мэргэжлийн үг хэллэг шинжлэх ухаан техник, нийгэм улс төрийн сэдвүүдийг орчуулахад багагүй үүрэг гүйцэтгэдэг. Нэр томъёог буруу орчуулснаас эх зохиолын утгыг сүрхий гажуудуулахад хүрдэг. Нэр томъёог зөв ойлгож, зөв орчуулахад

---

<sup>112</sup> С.Галсан. Бүх нийтийн орос хэлний боловсрол. УБ, 1977, стр 101

мэргэжлийн бус үг хэллэгээс нэр томьёог ялгаж өгдөг утгазүйн онцлогуудыг мэдэх хэрэгтэй.

Үүнд:

1. хам сэдэвтэй өвөрмөц харилцан үйлчилгээтэй;
2. дотоод хэлбэр онцгой үүрэгтэй,
3. олон улсын чанартай нэр томьёо ихэд дэлгэрсэн байдаг эдгээр болно.

### 1. Нэр томьёо хам сэдвийн харилцан үйлчлэлцэх онцлогоос

Нэр томьёо тодорхой ухагдахуунтай холбоотой, ямагт ганц утгатай байхыг эрмэлздэг. Нэлээд нэр томьёо хам сэдвээс үл хамаарах бөгөөд гагцхүү тэднийг үгийн сангийн хувьд дүйх үгээр нь орчуулж болно.

Жишээ нь ямар ч хам сэдэвт орос хэлний кислород, водород гэдэг нэр томьёо хүчилтөрөгч, устөрөгч гэж буух бөгөөд кислородное голодание (хүчилтөрөгчийн дутагдал), водородная бомба (устөрөгчийн бөмбөг) гэж нийлэмжид орсон ч ялгаагүй.

Өөр нэг эдийн засгийн нэр томьёо авч үзье.

Продукция-бүтээгдэхүүн, валовая продукция-нийт бүтээгдэхүүн, произведённая продукция-үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, промышленная продукция-үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, реализованная продукция-борлуулсан бүтээгдэхүүн, сельскохозяйственная продукция-хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, товарная продукция-таваарын бүтээгдэхүүн гэх мэт ямар ч хам сэдэвт дандаа бүтээгдэхүүн гэж орчуулагддаг.

Гэхдээ энэ нь нэр томьёо хам сэдэвт огт хамаагүй гэсэн үг бишээ.

Нэр томьёо нэг бус хэд хэдэн утгатай хааяа байна, уг нэр томьёо чухам ямар утгаараа орсныг хам сэдвээс нь л бид мэддэг. Хэд хэдэн янзаар орчуулагддаг нэр томьёо ч бий. Жишээ нь: «государство» гэдэг улс төрийн нэр томьёог монгол хэлнээ «төр», «улс» гэж хоёр янз орчуулна. «Государство и право» гэдэг сурах бичгийн нэрийг бид «Төр эрх» гэж, В.И Ленин «Государство и революция» гэдэг зохиолын нэрийг «Төр ба хувьсгал» гэж орчуулсан. Государственный университет, государственный банк гэсэн нийлэмж үгийг «улсын их сургууль», «улсын банк» (төрийн банк гэхгүй) гэж орчуулдаг. Маоистское руководство Китая все Хятадын эрх баригчид **улсуудын** более нагнетает атмосферу недоверия и **хооронд үл** итгэх, дайсагнах уур вражды между **государствами.** амьсгалыг дэвэргэж байна.

Дээрх өгүүлбэрт « государство »-г бид «улс» гэдгээр нь орчуулав.

б) Орчуулганд нэр томьёоны «дотоод хэлбэрийн» гүйцэтгэх үүрэг.

Нэг үгээр бүтсэн нэр томьёог өөр хэлнээс орчуулахад бидэнд нэр томьёоны болон хоёр хэлний толь бичиг тусална.

Тэмдэгдэж буй ухагдахуун нь ижил, салаа утгагүй утгазүйн найруулгын өнгө адил дүйх үг өөр өөр хэлэнд байж нэр томьёоны утгаар хэрэглэгдэж байвал орчуулганд тэр л үгээр нь бид орчуулна. Харин үүсмэл нэр томьёог бүдүүвчээр нь задлан уг үгийн язгуурыг голлон шинжилж ямар хэлний гаралтай язгуур байна, уг язгуурт ямар утгатай дагавар нэмэгдэж уг нэр үүссэнийг сайтар тунгаавал зохино.

Ихэнх нэр томьёоны «дотоод хэлбэр» буюу агуулга нь мэдэгдэж байх бөгөөд дүйх монгол нэр томьёотойгоо бүтцээрээ тохирч байдаг.

Ганц үгээр илэрсэн зарим нэр томьёоны « дотоод хэлбэр » тодорхой байвч агуулганд дүйх хувилбарыг сонгож олоход амаргүй байх тохиолдолд бий.

«Land slide» гэдэг англи нэр томьёо газар доош суух, нуралт, гулгалт, тасрах гэх мэт утгатай. Гэтэл улс төрийн сэдэвт in the General Election of July 1945 their was a labour land slide гэдэг үгийг дээрх утгаар нь «дотоод хэлбэр» -ийг барьж орчуулбал алдаа мадаг гарна.

«Лейбористуудын уналт» (сүйрэл)

Гэтэл уг сэдэвт лейбористуудын уналт бус харин ч олонхийн санлаар лейборист нам сонгуульд давамгайлан ялсныг хэлж байна.

Харин нийлэмж үгээр бүтсэн нэр томьёоны хувьд бол «дотоод хэлбэр» тодорхой байх нь орчууооход их дөхөм үзүүлэх бөгөөд нийлэмж үгийн гишүүдийн утгыг л мэдэх нь чухаг. Жишээ нь: временное правительство-түр засгийн газар, вооруженное восстание-зэвсэгт бослого, умственный труд- оюуны хөдөлмөр, финансовые ресурсы-санхүүгийн нөөц, козий пух-ямааны ноолуур, оборот переменного капитала-хувьсах капиталын эргэлт, относительная истина-харьцангуй үнэн, критерий истины-үнэний шалгуур, гигиена женщины-эмэгтэйчүүдийн эрүүл ахуй, инфекционное заболевание-халдварт өвчин (заразная болезнь), жаропонижающее средство-халууны эм (халуун дарах эм), народный суд-ардын шүүх, примерный устав-үлгэрчилсэн дүрэм, принудительное лечение-албадах эмчилгээ, прокурорский надзор-прокурорын хяналт, холодная война (Cold war)-хүйтэн дайн, эксплуатационный инженер-ашиглалтын инженер, зернодробилка-үр бутлагч, противотанковая артиллерия-танк эсэргүүцэх их буу гэх мэт.

Гэхдээ тэр болгон үгчлээд байж болохгүй, монгол хэлнийхээ зүй тогтол, хэм хэмжээг харгалзан үзэх ёстой.

Оросын язык и литература гэсэн хэллэгийг бид «хэл зохиол» гэсэн хоршоо үгээр орчуулдаг. Уг нь үгчлэн буулгавал хэл ба утга зохиол гэсэн санаа. Энд бид үгчлэхгүйгээр цаад ухагдахуунаа бүрэн гаргасан үгээр басхүү монгол хэл зүй, монгол хэлний найруулга зүйн үүднээс яаж хэлбэл монгол хэлний ёсонд илүү нийцтэй эвтэй болохыг бодолцжээ<sup>113</sup>.

Үгчлэн орчуулахдаа санаа нь ерөнхийдөө буувч цаанаа нэгэнт утга ижил, хэдийн тогтсон, хэллэгтэй нэр томьёо нэлээд бий. Жишээ нь: «слонный камень» гэдгийг бид үгчлэн «шүлсний чулуу» гэж болох авч монгол хэлэнд эртнээс нааш үүнийг «шүлсний гиваан» (лимонит) гэж нэрлэсээр ирсэн. Монголчуудад «хүнд нэг ухаан, үхэрт нэг гиваан» гэсэн зүйр үг ч байдаг. Гиваан гэж шаргалдуу өнгийн шороо, чулуу, хааяа бас үхэр, зааны гэдэснээс гардаг бөгөөд түүнийг эмнэлэгт хэрэглэж байжээ.

Зарим нэр томьёоны дотоод хэлбэр тодорхой, илт орчуулахад түвэггүй мэт болж ирээд үнэн хэрэгтээ хэцүү байх нь цөөнгүй. Жишээ нь: эдийн засгийн нэр томьёо dollar

<sup>113</sup>Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр. УБ., 1967, 3-р тал

export (англиар) үг үгээр нь хөөж орчуулбал долларын экспорт (экспорт долларов) гэж байгаа мэт. Гэвч тийм биш юм. Харин бүр эсрэг утгатай шахуу үг аж Dollar export гэдэг нь Англид доллар гаднаас орохыг нэмэгдүүлэх зорилгоор долларын бүсийн орнуудад бараа таваар гаргахыг хэлдэг байна.

Энэ нь долларыг гадаадад гаргах (экспорт) бус, харин ч гаднаас оруулж ирэх арга юм.

Иймээс энэ мэт нэр томъёоны «дотоод хэлбэр»-ийг үгчлэн буулгах замаар орчуулах тохиолдол гарвал их л болгоомжтой, цаад утга нь уг нэр томъёоны мөн чанарыг илтгэж бүрэн чадсан байна гэсний л үндсэн дээр нь энэ аргыг хэрэглэх хэрэгтэй.

Олон улсын шинж чанартай нэр томъёог бичиг зохиолд орчуулалгүй авч хэрэглэхдээ тухайн сэдвийн найруулгад хэр нийцэж байгаа, уг үг монгол хэлэнд хэр зэрэг их хэрэглэгддэг мэтийг бас анхаарч үзэх хэрэгтэй.

Гадаад хэлнээс зээлдсэн нэр томъёоны талаар дээр өгүүлсэн билээ. Зарим тохиолдолд олон улсын шинж чанартай нэр томъёо монгол нэр томъёотой тодорхой хугацаанд эн зэрэгцэн хэрэглэгдэж, эцэст нь аль нэг нь зонхилох болдог. Жишээ нь: Социализм-нийгэм журамт ёс. Коммунизм-эв хамт ёс; аптека-эмийн сан, аптека; стадион-цэнгэлдэх хүрээлэн, стадион; ясль-хүүхэд саатуулах газар, ясль гэх мэтээр зэрэгцэн хэрэглэгддэг. Одоо социализм, коммунизм гэж дандаа бичих болж (орчуулгын) монгол нэр томъёо нийгэм журамт ёс, эв хамт ёс гэдгийг бараг хэрэглэхээ больжээ. Харин дээрх бусад үгийн хувьд хоёр янз ярьж бичсээр байна.

Англи хэлний «compositor» гэдэг үг латин хэлний «componere» гэдэг үгнээс үүссэн бөгөөд «үсэг өрөгч» гэсэн утгатай аж. Гэтэл энэ үгтэй ижил дуудагддаг **композитор** гэдэг үг орос хэлэнд хөгжмийн зохиолч гэсэн санааг илтгэнэ. Энэ мэт гаднаас нь харахад ижил үг юм шиг, утгаараа эрс өөр үгийг олон улсын чанартай хуурамч үг (псевдоинтернациональные слова) гэдэг. Тийм үгийг орчуулахад нилээд бэрхшээлтэй. Тийм ч учраас иймэрхүү үгийг орчуулгын онолд «орчуулагч нарын хуурамч нөхөд» (Ложные друзья переводчика) гэж нэрлэх ёс бий. Орос, англи зэрэг европ зүгийн хэлнүүдэд тийм үзэгдэл элбэг.

«Орчуулагчийн хуурамч нөхдийн» талаар профессор Р.А.Будагов «Человек и его язык» (хүн, хүний хэл) гэдэг номондоо найман янзын харьцаанд хувааж нэлээд тодорхой авч үзсэн. Одоо үед хэлэнд байх тийм үг хэллэгийг тусгайлан түүвэрлэж толь бичгүүдэд гаргаж байна.

Орчуулагчийн «хуурамч нөхдийн» заримаас орос, англи зэрэг хэлний хэрэглэгдэхүүн дээр хэдэн жишээ татъя. Доорхи үгсийг харахад хэлбэрээр ойр боловч агуулгаараа огт өөр.

Үүнд:

Актуальный (цаг үеийн чухал) actual

(действительный (үнэхээр бодит)

Аспирант aspirant (претендент-өрсөлдөгч)

Декада 10 хоног decade (арван жил) prospect

Проспект (өргөн гудамж) prospect (ирээдүй)

Идиома (орос монголоор хэлц үг,

Өвөрмөц хэллэг idiom испаниар ер нь л «хэл»

Галантний ( оросоор гагцхүү найрсаг гэсэн утгатай байхад англиар gallant (салаал утгатай) зориг баатарлаг, гоё ганган, эелдэг найрсаг гэх мэт.

Оросоор фельетон (шог аястай зохиол) францаар feuilleton үргэлжлэн гарах романаас авч сонинд тавьсан хэсэг, философийн «идеализм» (орос монгол хэлэнд ижил) гэдэг нэр томъёо материализмд харш чиглэлийг хэлдэг. Харин англи зэрэг хэлэнд улс төрийн idealism гэдэг нэр томъёо «ариун зарчим, дээд эрмэлзэлд үйлчилэх» гэсэн өөр утгаар голдуу хэрэглэдэг байна.

Нэр томъёог дараахь аргуудаар ихэнх тохиолдолд орчуулдаг. Үүнд: 1. Үгсийн сангийн үүднээс таарч тохирох үг эх хэлнээсээ сонгон орчуулах, энэ нь хамгийн түгээмэл арга болно. Гэхдээ хэлбэр, бүтцээрээ орос нэр томъёотой дүйхгүй монгол нэр томъёогоор орчуулах тохиолдол олонтаа. Жишээ нь: телесне наказание-ташуурдах ял, рак-өмөн үү, игла морская-тэвнэ загас, министр без портфеля-төрийн сайд гэх мэт.

Хэлний дотоод бололцоонд түшиглэн шинэ нэр томъёо үүсгэхдээ уг зүйлийн агуулга, зориулалтыг нь бодолцдог. Жишээ нь: термос-«халуун сав», «градусник»-«халууны шил», телеграмма-цахилгаан, мясорубка-махны машин гэх мэт.

2) галигчлан буулгах

Атом, аппарат, материализм, автобус, рубль, конгресс, Кремль, стресс гэх мэт.

3) хуулбарлан (үгчлэн) орчуулах

Встречный план-угтвар төлөвлөгөө

Наука и жизнь-шинжлэх ухаан, амьдрал

Развитой социализм-хөгжингүй социализм

Формальная логика-формаль логик

Комплексный подход-иж бүрнээр хандах (иж бүрэн хандлага)

4) дүйх нэр томъёоны бүтцийг нэг хэсгийг үгчлэн орчуулж, нөгөө хэсгийг галигчлан буулгах:

Коммунистическая партия-коммунист нам

Абсолютный идеализм-үнэмлэхүй идеализм

Автономная республика-автономит бүгд найрамдах улс

Авторемонтный завод-авто засварын завод

Телевизионная передача-телевизийн нэвтрүүлэг гэх мэт.

5) үгсийн сангийн бололцоотой хоёр хувилбарын аль нэгийг сонгон авах:

Аптека-аптек, эмийн сан, ангина-ангин, бах:

Аборт-аборт, үр хөндөх, зулбаа

Философия-философи, гүн ухаан, автономия-автономи, өөрөөн засах

(Галигчлах тоймлон орчуулах арга хоёрын аль нэгийг сонгох: Уг ухагдахууныг тэмдэглэж буй нэр томъёо манай хэлнээ шинэ тутам үед галигчлан буулгаж хаалтан дотор утгыг тоймлон бичнэ. Пентагон-гэсэн үгийг пентагон ч гэдэг,

заримдаа АНУ-ын цэргийн яам, волонтаризм-волонтаризм) бодит зүй тогтлыг үгүйсгэгч субъектив идиалист чиглэл гэх мэт.

Нэр томъёог монгол хэлнээ үнэн зөв орчуулахын тулд дараахь гурван зүйлийг ямагт анхаарч байх хэрэгтэй. Үүнд:

а) нар томъёо хам сэдэвтэйгй харилцан шүтэлцээтэй байдаг онцлогийг мэдэх

б) нэр томъёо орчуулагддаг үндсэн аргыг сайтар судлан, шинжлэх ухааны тухайн салбарын монгол нэр томъёоны гүн бат мэдлэгтэй байх

в) монгол хэлнээ байгаа ойролцоо утгатай үг, хэллэг, нэр томъёоноос чадварлаг сонгож авах, шинээр нэр томъёо зохиож өгөхдөө хамгийн үр дүнтэй аргыг шилж сонгож чаддаг байх, эдгээр болно.

Нэг хэлнээ ижилдүү ухагдахууныг их нарийвчлан зааглаж, тэр болгон тусгай нэр өгсөн байхад нөгөө хэлнээ тэр болгоныг төдийлөн ангилдаггүй нэг л үгээр (нэр томъёогоор) хэлдэг тохиолдолд нэг хэлнээс нөгөөд орчуулахдаа нэг үгээр өөр өөр үг орчуулах (Жишээ нь: үүрэг гэдэг үгээр орос хэлний **обязанность, обязательство долг**, заримдаа **задача, нагрузка** гэснийг ч орчуулахад хүрдэг) эсвэл өөр өөр үгийг нэр үгээр (**метод, способ, приём** гэдэг нэр томъёо зарим утгаараа **арга** гэж **разум, дух** гэдэг философийн нэр томъёог ухаан санаа, оюун санаа гэж ижил орчуулдаг) буулгахад хүрдэг. Энэ нь нэр томъёоны орчуулгын бас нэгэн бэрхшээлтэй тал юм.